



I-IX/2021


Тархаасан: 2021 оны 11 дүгээр сарын 9



Мэдээлэл, харилцаа холбооны салбарын орлого өмнөх улирлаас 3.6 хувиар өслөө

Улсын хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2021 оны эхний 9 сард 1.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 136.5 (13.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ОРЛОГО, улирлаар, тэрбум төгрөг



Энэхүү өсөлтөд цахилгаан холбооны үйл ажиллагааны орлого 112.5 (14.3%) тэрбум төгрөг, өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагааных 13.2 (10.3%) тэрбум төгрөг, шуудангийн үйл ажиллагааных 7.6 (42.0%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөн мэдээлэл, харилцаа холбооны салбарын нийт орлого 2021 оны 3 дугаар улиралд 412.6 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 14.4 (3.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 VII-IX	2020 VII-IX	2021*VII-IX
Суурин утасны цэг, мян. шир	318.7	314.1	310.5
Үүрэн утас идэвхтэй хэрэглэгчид (давхардсан тоогоор), мян. хүн	4 384.5	4 439.6	4 569.9
Кабелийн телевизийн идэвхтэй хэрэглэгчид	907 593	913 088	948 468

Суурин утасны цэгийн тоо 2021 оны 3 дугаар улиралд 310.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.6 (1.1%) мянган цэгээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар хотын суурин утасны цэг 5.0 (1.9%)

мянгаар буурсан нь нөлөөлсөн байна.

Кабелийн телевиз хэрэглэгчид 2021 оны 3 дугаар улиралд 948.5 мянга болж, өмнөх оны мөн үеэс 35.4 (3.9%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Кабелийн телевиз хэрэглэгчид өсөхөд Орхон аймагт 9.8 (35.1%) мянга, Хөвсгөл аймагт 4.9 (17.2%) мянга, Дорноговь аймагт 3.2 (16.4%) мянга, Ховд аймагт 2.4 (14.4%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь нөлөөлөв.

Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид 2021 оны 3 дугаар улиралд 4.6 (давхардсан тоо) сая болж, өмнөх оны мөн үеэс 130.3 (2.9%) мянган хэрэглэгчээр өссөн байна. Үүрэн утасны идэвхтэй хэрэглэгчид өсөхөд Улаанбаатар хотод 170.0 (7.6%) мянга, Дархан-Уул аймагт 5.8 (4.8%) мянга, Ховд аймагт 5.4 (5.6%) мянга, Баян-Өлгий аймагт 4.3 (4.3%) мянга, Увс аймагт 2.7 (2.9%) мянган хэрэглэгчдээр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Интернэт хэрэглэгчдийн тоо 2021 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 1.9 хувиар өсөж, 4.1 сая болжээ. Энэхүү өсөлтөд үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгч 61.5 (1.7%) мянга, гэрээт интернэт хэрэглэгчид 76.7 (4.4%) мянгаар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт шуудан, илгээмжийн хэмжээ 2021 оны 3 дугаар улиралд 1.4 сая ширхэг болж, өмнөх улирлаас 166.6 (10.7%) мянган ширхгээр буурсан байна. Энэхүү бууралтад дотоодын шуудан, илгээмж 173.2 (11.8%) мянга, улс хоорондын гарах шуудан, илгээмж 4.8 (23.7%) мянга ширхгээр буурсан нь нөлөөлсөн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2021 оны эхний 9 сард 709.4 мянган ширхэг бичиг, захидал, 212.5 мянган ширхэг боодол, 334.3 мянган ширхэг илгээлт, 160.5 мянган ширхэг буухиа, 526.6 мянган ширхэг бизнес захидал, 196.3 мянган ширхэг гибрид шуудан, 55.6 мянган ширхэг цахим худалдааны илгээмж, 2.2 сая ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ.

ХҮСНЭГТ 2. ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Шуудан илгээмжийн урсгал	Бүгд		Дотоод шуудан		Улс хоорондын гарах		Улс хоорондын орох	
	2020 I-IX	2021*I-I-IX	2020 I-IX	2021*I-I-IX	2020 I-IX	2021*I-I-IX	2020 I-IX	2021*I-I-IX
	мянган ширхэг							
Нийт шуудан, илгээмж	6 200.5	4 413.7	5 957.1	4 119.5	67.6	66.9	175.7	227.3
Бичиг захидал	774.4	709.4	703.0	645.2	28.6	16.2	42.8	48.0
Боодол	100.1	212.5	45.8	152.8	7.3	9.4	47.0	50.3
Илгээлт	154.5	334.3	75.9	239.5	19.2	25.6	59.4	69.2
Буухиа	86.0	160.5	47.1	85.1	12.4	15.7	26.5	59.7
Бизнес захидал	601.8	526.6	601.8	526.6	-	-	-	-
Гибрид шуудан	145.0	196.3	145.0	196.3	-	-	-	-
Цахим худалдааны илгээмж	18.2	55.6	18.2	55.6	-	-	-	-
Хэвлэл	4 320.4	2 218.4	4 320.4	2 218.4	-	-	-	-

Ойлголт, тодорхойлолт

Суурин телефон цэг гэж нийтийн телефон сүлжээнд хэрэглэгчийн шугамаар телефон станц дээр порт эзлэн зориулалтын төхөөрөмжөөр холбогдсон эцсийн хэрэглэгчийг ойлгоно.

Сансрын холбооны хэрэглэгчид гэж сансрын хиймэл дагуул ашиглан холбогдож буй холбооны хэрэглэгчийг ойлгоно.

Интернэтийн байнгын хэрэглэгчид гэж сар бүр тодорхой хэмжээний төлбөр төлж интернэтийг тогтмол хэрэглэдэг хэрэглэгчийг ойлгоно.

Гибрид шуудан гэж хэрэглэгчээс мэдээллийг файл хэлбэрээр хүлээн авч, хэвлэн дугуйлан битүүмжилж хаягт эзэнд нь хүргэх шуудангийн илгээмж юм.

Боодол гэж тодорхой этгээдэд хаягласан, эд зүйлс агуулсан битүүмжлэгдсэн шуудангийн илгээмжийг ойлгоно.

Илгээлт гэж боодлоос овор хэмжээгээрээ том шуудангийн илгээмж юм.



Эх үүсвэр:

ҮСХ, холбооны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 2 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын

дарга А.Дэмбэрэл

Утас: (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын Мөнгө,

санхүү, үйлчилгээний статистикийн хэлтсийн

ахлах статистикч О.Мандахзориг

Утас: (976-51)-264797

